



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/330

Номгон

Г Газар албадан чөлөөлөх ажлын хэсэг Г  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 57 дугаар зүйлийн 57.4, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сум, Шаргалжуут 8-р багт Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, аялал жуулчлалын бааз байгуулах зорилгоор Шаргалжуут гол, рашааны хамгаалалтын зурвас газарт зөвшөөрөлгүйгээр хашаа, хайс хатгасан, байшин барилга барьсан иргэдийн газрыг албадан чөлөөлөх ажлыг 2023 оны 06 дугаар сарын 20-28-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.


2.Дээрх ажлын зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр газар эзэмшсэн иргэний хашаа, хайс, барилгыг хуулийн хүрээнд албадан буулгаж, газрыг чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээр гаргуулж газрыг хэвийн байдалд оруулан ажиллахыг Ажлын хэсэг (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

4.Газар чөлөөлөх, албадан нүүлгэхэд эсэргүүцсэн, хүч хэрэглэсэн буюу зохион байгуулалттайгаар саатуулах үйлдэл гаргахаас урьдчилан сэргийлж, зохих журмын дагуу арга хэмжээ авч, хэв журам сахиулахыг Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Д.Мөнгөнтулга)-д үүрэг болгосугай.

5.Албадан буулгах үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, ажлын үр дүнг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

842310819

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар  
сарын 15 -ны өдрийн 1730 дугаар захирамжийн



## ГАЗАР АЛБАДАН ЧӨЛӨӨЛӨХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Т.Хишигбаатар	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Гишүүд: Г.Энхбаяр	Баянхонгор сумын Засаг дарга
Д.Цэвэгдорж	Эрдэнэцогт сумын засаг дарга
Б.Ням-Очир	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны дарга
Д.Мөнгөтулга	Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа
Х.Цэнд-Очир	Онцгой байдлын газрын Аврах, гал унтраах 16-р ангийн захирагч, ахмад
Ц.Уянга	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Байгаль орчин, газар, Геодези зурагзүйн хяналтын улсын байцаагч
С.Должинсүрэн	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
Х.Баасанжаргал	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Баянхонгор сумын газрын даамал
Б.Нармандах	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Баянхонгор сумын газрын даамал
Д.Номинчимэг	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Эрдэнэцогт сумын газрын даамал
Нарийн бичгийн дарга: А.Цэцэнбилэг	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_